

ДАГАЛДАХ ХУУЛЬ, ТҮҮНД ТАВИГДАХ ШААРДЛАГА: ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ДАГАЛДАХ ХУУЛИУДАД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

“Онч шийдэл” НҮТББ

Ш.Алтангадас, судалгааны багийн ахлагч, Б.Цэрэнлхам, судлаач

У.Пэрэнлэйжамц, судлаач, Ө.Эрдэнэ-Очир, судлаач

АСУУДЛЫН ТАНИЛЦУУЛГА

Төрийн эрх мэдлийн нэг үндсэн хэсэг болох хууль тогтоох эрх мэдлийг ард түмнээс сонгогдон байгуулагдсан парламент хэрэгжүүлж, эрх зүйн хэм хэмжээ агуулсан хуулийг батлан гаргах замаар нийгмийн харилцааг зохицуулж байдаг. Батлагдсан хууль тогтоомж нь улс орон, иргэд, байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг зөвөөр уялдуулан зохицуулах, зөрчил сөргөлдөөнөөс урьдчилан сэргийлэх, эвлэрүүлэн тохируулахад нийтээр дагах хэм хэмжээ болж мөрдөгддөг.

Хууль тогтоох үйл ажиллагаа нь нийгмийн бодит хэрэгцээ шаардлагад тулгуурласан, нарийвчилсан тооцоо, судалгаанд үндэслэсэн, хуулиар тусгайлан тогтоосон процессын дагуу явагдах ёстой бөгөөд энэ шаардлагыг 2015 онд батлагдсан Хууль тогтоомжийн тухай хуулиар тогтоожээ.

Гэвч сүүлийн жилүүдэд хууль тогтоох үйл

ажиллагаанд дээрх хуулиар тогтоосон дэг журам алдагдах болж, холбогдох тооцоо судалгаа, олон нийтийн хэлэлцүүлгийг зохих ёсоор хийхгүй байх, хуулийн төслийн агуулга, бичвэрт тавигдах шаардлагыг зөрчих явдал гарах болсон нь үндэсний эрх зүйн тогтолцооны системчлэлийг алдагдуулж, эцэстээ хууль тогтоох үйл ажиллагааны үр нөлөө буурч, хүний эрх, эрх чөлөө зөрчигдөх нөхцөлийг бүрдүүлэхэд нөлөөлж байна. Ялангуяа энэ байдал нь төсвийн тухай хууль, түүний дагалдах хуулиудад илүүтэй ажиглагдаж байна. Өөрөөр хэлбэл, жил бүр улсын төсвийг батлахад дагалдах хууль нэрээр анхдагч хууль батлах, эсхүл хүчин төгөлдөр хууль тогтоомжид зарчмын шинжтэй томоохон өөрчлөлт оруулах явдал гарах боллоо.

Тухайлбал, Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийг дагалдуулан Засгийн газар дахь хяналтын тухай хууль, Төрийн хэмнэлтийн



ШАГДАРСҮРЭНГИЙН АЛТАНГАДАС /LL.M/

Өмгөөллийн “Онч нүүдэл” ХХН-ийн үүсгэн байгуулагч, партнер өмгөөлөгч. “Онч шийдэл” ТББ-ын Удирдах зөвлөлийн дарга

2010 онд МУИС-ийн Хууль зүйн сургуулийг эрх зүйч мэргэжлээр төгсөж, 2016-2017 онд Лондонгийн өмнөд эргийн их сургууль (London South Bank University)-д хууль зүйн магистрын зэрэг хамгаалсан.



ӨЛЗИЙГИЙН ЭРДЭНЭ-ОЧИР

Өмгөөллийн “Онч нүүдэл” ХХН-ийн үүсгэн байгуулагч, партнер өмгөөлөгч.

2010 онд МУИС-ийн Хууль зүйн сургуулийг эрх зүйч мэргэжлээр төгссөн. 2012 оноос одоог хүртэл өмгөөллийн “Онч нүүдэл” ХХН-д партнер өмгөөлөгч, “Онч шийдэл” ТББ-ын гүйцэтгэх захирлаар тус тус ажиллаж байна.



БАТ-ЭРДЭНИЙН ЦЭРЭНЛХАМ

Өмгөөллийн “Онч нүүдэл” ХХН-ийн хуульч, судлаач.

2020 онд МУИС-ийн Хууль зүйн сургуулийг эрх зүйч мэргэжлээр төгссөн. 2020 оноос өмгөөллийн “Онч нүүдэл” ХХН-д хуульч, “Онч шийдэл” ТББ-д судлаачаар ажиллаж байна.



УРАНЧИМЭГ ПЭРЭНЛЭЙЖАМЦ

“Онч шийдэл” ТББ-ын судлаач.

2021 онд МУИС-ийн Хууль зүйн сургуулийг эрх зүйч мэргэжлээр төгссөн. 2022 оноос өмгөөллийн “Онч нүүдэл” ХХН-д хуульч, “Онч шийдэл” НҮТББ-д судлаачаар ажиллаж байна.

тухай гэх анхдагч хуулиудыг баталсан, мөн Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, татварын хувь хэмжээг нэмэгдүүлсэн зэрэг нь Хууль тогтоомжийн тухай хуульд нийцсэн эсэх талаар холбогдох мэргэжилтнүүд харилцан адилгүй байр суурьтай байна. Өөрөөр хэлбэл, анхдагч хуулийн төслийг хэрэгцээ шаардлагын тандан судалгаагүйгээр хийж болох эсэх, татварын хувь хэмжээг олон нийтийн хэлэлцүүлэг өрнүүлэхгүйгээр нэмэгдүүлж болох эсэх, ерөөс дагалдах хуулиуд нь төсвийн тухай хууль, түүнийг хэрэгжүүлэхэд хамаарах эсэх нь олон нийтийн шүүмжлэл

дагуулсаар байна.

Иймд аливаа хууль тогтоомжийг дагалдуулан бусад хуульд нэмэлт өөрчлөлт оруулахад ямар журмыг дагаж мөрдөх, ямар шалгуур, хязгаарлалтыг баримтлах зэрэг асуудлыг судлах замаар “дагалдах хууль” гэх ойлголтын агуулга, шалгуур үзүүлэлтийг хууль зүйн үүднээс тодорхойлон хэлэлцүүлэг өрнүүлэх хэрэгцээ урган гарч байна. Иймээс гадаад орнуудын хууль тогтоох үйл ажиллагаа дахь хууль батлах, дагалдаж гарах хуулийг харьцуулан судлалаа.

ӨНӨӨГИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Дагалдах хуулийн ойлголт

Монгол Улс анх 2001 онд Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хууль батлан хуулийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх харилцааг журамлан зохицуулжээ. Энэ хуульд дагалдах хууль гэх тусгайлсан ойлголт, нэр томъёо тусгагдаагүй боловч агуулгын хувьд төсөөтэй зохицуулалт туссан байжээ. Харин дагалдах хууль гэх ойлголт 2017 оноос мөрдөж байгаа Хууль тогтоомжийн тухай хуульд анх орсон боловч хуулийн төслийг дагалдуулан ямар нэг өөр хуулийг өөрчлөхөд баримтлах журам, шалгуур, хязгаарлалтыг тодорхой тусгаагүй байна. Үүнээс үүдэн Хууль тогтоомжийн тухай хуулиар тогтоосон хуулийн төсөлд тавих агуулга, хэлбэр, процессын нийтлэг шаардлага дагалдах хуулийн төсөлд үйлчлэхгүй явсаар иржээ.

“Дагалдах” гэдэг нь үг зүйн хувьд “дагах”-ын гэсэн үгний үйлдэгдэх хэв бөгөөд дагах, өмнөх зүйлд нийцэх, аялдан дагах гэсэн утгыг илэрхийлэх¹ тул дагалдах хууль нь дагаж байгаа хуультайгаа агуулгын хувьд уялдаа, хамааралтай байх ёстой гэсэн санааг илэрхийлж байна. Хууль тогтоомжийн тухай хуульд “дагалдах хууль”-тай холбоотой дараах ойлголт туссан байна. Үүнд:

- “хууль тогтоомжийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах,

шинэчлэн найруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох”;²

- “... хууль тогтоомжийн төсөл ... харилцан уялдаа”;³
- “шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулна”;⁴
- “Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн, бусад хууль болон Монгол Улсын олон улсын гэрээний заалттай уялдсан байх”;⁵
- “... хууль тогтоомжийн төсөлд дараах баримт бичгийг хавсаргана” ... “дагалдаж өөрчлөлт оруулах хууль тогтоомжийн төсөл”⁶ хэмээн тус тус хуульчлагджээ.

Эдгээр ойлголтыг эрх зүйн хэм хэмжээг системчлэх болон тайлбарлах логик аргын⁷ үүднээс авч үзвэл дагалдах хуулийн агуулга нь тухайн боловсруулж буй хууль тогтоомжийн төслийн үзэл санаа, зохицуулалтыг хэрэгжүүлэхийн тулд тухайн салбарын эсхүл тухайн харилцаа холбоотой бусад хууль тогтоомжид зайлшгүй өөрчлөлт (нэмэлт өөрчлөлт, хүчингүй болгох гэх мэт) оруулах шаардлага үүссэн байх утгыг илэрхийлж байна.

Шинээр баталж буй хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай байх шалгуурыг логик аргын хүрээнд авч үзвэл Төсвийн хуулийг дагалдуулан бусад хуульд оруулж байгаа

1 Монгол хэлний их тайлбар толь. Цахим хувилбар

2 Хууль тогтоомжийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.4 дэх заалт

3 Хууль тогтоомжийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1 дэх заалт

4 Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3 дахь хэсэг

5 Хууль тогтоомжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.1 дэх заалт

6 Хууль тогтоомжийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэг

7 Д.Баярсайхан. Эрх зүйн онол. 2016 он, 186 тал

өөрчлөлт нь Төсвийн тухай хуулийн зорилго, зохицуулалттай нийцсэн, түүнийг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх шаардлага тавигдаж байна. Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1-д “... хуулийн зорилт нь Монгол Улсын төсөвт 2023 оны төсвийн жилд төвлөрүүлэх орлого, зарцуулах төсвийн хэмжээ, орлого төвлөрүүлэх байгууллага, орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон улсын төсвөөс Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг,

орон нутгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх орлого, төсвийн ерөнхийлөн захирагчид төсөв зарцуулах эрх олгох, Төсвийн тогтворжуулалтын болон Ирээдүйн өв санд хуримтлуулах хөрөнгийн хэмжээ, төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр, мөнгөн гүйлгээтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино”⁸ гэж заасан бөгөөд уг хуулийг дагалдан батлагдаж буй хууль нь уг зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх шаардлагад нийцэх учиртай.

Хууль тогтоомжийн төсөл боловсруулахад тавигдах шаардлагын хэрэгжилт

Улсын Их Хурлаас 2015 онд баталсан Хууль тогтоомжийн тухай хуулийн зорилго нь “хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг санаачлан боловсруулах, хууль тогтоомжийн төсөлд тавигдах шаардлагыг тодорхойлох, олон нийтийн оролцоог хангах, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, батлагдсан хууль тогтоомжийг нийтлэх, сурталчлах, түүний хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах”⁹ юм. Уг хууль 2017 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хэрэгжиж байна.

Аливаа хуулийн төсөл нь холбогдох тооцоо, судалгаанд үндэслэх бөгөөд эдгээр судалгааг Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасны дагуу Засгийн газраас баталсан дараах аргачлалын дагуу хуулийн төсөл боловсруулагч хийж гүйцэтгэнэ. Үүнд:

- Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал;
- Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал;
- Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал;
- Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал;
- Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал.

Эдгээрээс хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалаас бусад аргачлал буюу хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлагыг тандан судлах, үр нөлөөг үнэлэх, зардлын тооцоог хийх болон хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалыг тухайн жилийн улсын төсвийн төсөл болон төсвийн тодотголд шаардахгүй.¹⁰

Тухайн жилийн улсын төсвийг батлахад хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлох

шаардлагагүй ч дагалдуулан өргөн мэдүүлж байгаа хуулийн төслүүдийг батлах шаардлага зайлшгүй эсэхийг тогтоож байх нь зүйтэй. Ялангуяа төсвийн хуулийг дагалдуулан өргөн мэдүүлсэн анхдагч хуулийн төсөлд энэхүү шаардлага зайлшгүй тавигдах учиртай.

Учир нь хэрэгцээ, шаардлагыг нь тандан судлахгүйгээр батлагдаж байгаа хуулиуд нь дараах асуудлыг үл харгалзан батлагдаж буй хэрэг юм. Үүнд:

- a. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуульд нийцэх эсэх;
- b. Тухайн асуудлыг хууль тогтоомжоор зохицуулах шаардлагатай эсэх;
- c. Тухайн асуудлыг зохицуулах эрх зүйн хэм хэмжээг тодорхойлох;
- d. Зохицуулах эрх зүйн хэм хэмжээний эерэг болон сөрөг талыг харьцуулан судлах;
- e. Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг урьдчилан тооцсоны үндсэн дээр тухайн асуудлыг шийдвэрлэх үр дүнтэй хувилбарыг тодорхойлох;
- f. Шаардлагатай тохиолдолд тухайн асуудлаар бусад улсын эрх зүйн зохицуулалтын талаарх судалгаа хийх.

Түүнээс гадна хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх асуудал ч орхигдож байна. Хууль тогтоомжийн тухай хуулийн 17 дугаар зүйлд зааснаар аливаа хуулийн төслийг боловсруулахад:

- a. Хууль тогтоомжийн төсөл, эсхүл түүний зарим зүйл, заалтын зохицуулалтын практикт хэрэгжих боломж, харилцан уялдааг тооцож шинжилгээ хийх;
- b. Хууль тогтоомжийн төслийн давхардал, хийдэл, зөрчил үүсгэхгүй байх;

8 Монгол улсын 2023 оны төсвийн тухай хууль

9 Хууль тогтоомжийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх заалт

10 Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйл

с. Тухайн хуулийг баталснаар үүсэж болзошгүй, урьдчилан тооцоогүй үр дагаврыг тодорхойлох шаардлага тавигддаг.

2011 онд батлагдсан Төсвийн тухай хуулиар зохицуулагдсан тухайн жилийн төсвийн төслийг боловсруулах, өргөн мэдүүлэх үйл явц нь Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалтаас ялгаатай байна.

Төсвийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2-т зааснаар Засгийн газар нь улсын төсвийн төслийг, танилцуулгын хамт мөн хуулийн 8.4-т заасан төсвийн цаглабарын дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх бөгөөд уг танилцуулгад тухайн жилийн төсөвтэй холбогдуулан шийдвэрлэх хууль тогтоомжийн төслийг багтаан хамт өргөн мэдүүлэхээр хуульчилжээ.¹¹ Тэрчлэн Хууль тогтоомжийн тухай хуульд 2017 онд нэмэлт өөрчлөлт оруулж, тооцоо судалгаагүйгээр батлах зарим хууль тогтоомжийг тодорхойлсны дотор улсын төсөв, төсвийн тодотгол багтсан байна.¹²

Иймээс тухайн жилийн төсөвтэй холбогдуулан батлах хууль тогтоомжид Хууль тогтоомжийн тухай хуулиар тогтоосон тооцоо судалгаа хийх шаардлага тавигдахгүй байна. Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 25-ний өдрийн 59 дүгээр тогтоолоор батлагдсан хууль тогтоомжийн төсөл боловсруулах, үр нөлөөг үнэлэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой зардал тооцох, хэрэгжилтийн хяналт хийх, үр дагаварт үнэлгээ хийх аргачлалууд нь тухайн жилийн төсвийн тухай хуультай хамт дагалдах хуулиудад хамаарахгүй байх эрх зүйн орчин бий болсон гэж дүгнэж болохоор байна.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5-8.1.6 дахь заалтын дагуу хуулийн төслийг эрх ашиг сонирхол нь хөндөгдсөн талуудаар хэлэлцүүлэх, холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн болон судалгааны байгууллагаас санал авах шаардлагатай. Хууль тогтоомжийн төсөл боловсруулахад тавигдах энэ бүх шаардлагыг төсвийн хуулийг батлах үед түүний дагалдах хууль тогтоомжийн төсөлд баримтлахгүй байна. Учир нь дээр дурдсанчлан тухайн жилийн төсвийн хуулийн танилцуулгын бүрдэлд багтсан

хуулийн төслүүдэд олон нийтийн хэлэлцүүлэг өрнөхгүй байна.¹³

Төсвийн тухай хуульд 2023 онд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр төсвийн төсөл боловсруулахад олон нийтийн оролцоог хангах зохицуулалт буюу 281 дугаар зүйлийг нэмсэн боловч энд дурдсан хэлэлцүүлэг нь дагалдах хуульд хамаарах эсэх нь ойлгомжгүй, тодорхойгүй байна. Өөрөөр хэлбэл, дагалдах хууль нь тухайн жилийн төсвийн тухай хуулийн төслийн бүрдэлд тооцогдох тул Төсвийн тухай хуулийн 281 дүгээр зүйлийн 281.1.1-д заасны дагуу “Төсвийн төсөл боловсруулахад олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулах” ёстой гэж ойлгож болохоор байна. Гэтэл төсөв өөрөө нарийн түвэгтэй, түүнийг боловсруулах, батлах үйл явц нь богино хугацаанд хийгддэгээс олон нийтийн хэлэлцүүлэг төдийгүй УИХ-ын байнгын хороо, чуулганы хэлэлцүүлэг нь бүхэлдээ төсвийн үндсэн асуудалд төвлөрч, дагалдах хуулиуд огт хэлэлцүүлэггүйгээр батлагдаж байна.

Хууль тогтоомжийн тухай хуульд дагалдах хуультай холбоотой зарим зохицуулалт тусгагдсан байх боловч уг нэр томъёоны хууль зүйн агуулга, дагалдах хуулийн төсөл, түүнийг тодорхойлоход тавих шаардлага, шалгуур тодорхой бус байна. Энэ нь дагалдах хууль хэлбэрээр Хууль тогтоомжийн тухай хуульд заасан тооцоо судалгаа, олон нийтийн хэлэлцүүлэг хийгдэхгүйгээр хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, тэр байтугай анхдагч хуулийг баглан гаргах жишиг тогтоход хүргэжээ. Тэрчлэн Хууль тогтоомжийн тухай хуульд удаа дараа нэмэлт өөрчлөлт оруулж, тооцоо судалгаа, олон нийтийн хэлэлцүүлэг хийх шаардлагад хамаарахгүй тохиолдлуудыг өргөжүүлж байгаа нь үүнд нөлөөлжээ. Ялангуяа энэ байдал нь төсвийн тухай хууль, түүний дагалдах хуулиудад илүү тод ажиглагдаж байна. Өөрөөр хэлбэл, төсвийн тухай хуулийн дагалдах хуулиуд нь Хууль тогтоомжийн тухай хууль болон Төсвийн тухай хуульд заасан олон нийтийн оролцооны журмын гадна үлддэг жишиг тогтсоныг анхаарах нь зүйтэй. Ийм учраас төсвийн дагалдах хууль нэг бүрийг тухайн жилийн төсөвтэй холбоотой эсэх буюу төсвийн хуультай хамт батлах зайлшгүй шаардлагатай эсэхийг нэг бүрчлэн тогтоох шаардлагатай байна.

МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ БАТЛАГДСАН

11 Төсвийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2.20 дахь заалт

12 Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэг

13 Төсвийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.20 дахь хэсэг

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ШИНЖИЛГЭЭ

Хууль тогтоомжийн тухай хуульд хуулийн төсөл нь анхдагч хуулийн төсөл, хуульд өөрчлөлт оруулах хуулийн төсөл, хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, багц хуулийн төсөл, хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл гэсэн төрөлтэй байхаар зохицуулсан. 2017 оноос хойш төсвийн тухай хуулийг дагалдаж хуульд орсон өөрчлөлтийг дээрх төрлөөр ангилан үзвэл,

Төсвийн тухай хуулийн дагалдах хуулийн хүрээнд гарсан анхдагч хууль:

- Засгийн газар дахь хяналтын тухай хууль – 2022.11.11-нд батлагдсан;
- Төрийн хэмнэлтийн тухай хууль – 2022.04.29-нд батлагдсан.

Төсвийн тухай хуулийг дагалдан батлагдсан шинэчилсэн найруулга:

Засгийн газрын тусгай сангийн тухай – 2019.11.13-нд батлагдсан.

Төсвийн тухай хуулийн дагаж нэмэлт өөрчлөлт оруулсан хуулийн тоо:

- 2017 онд 15 хууль;
- 2018 онд 8 хууль;
- 2019 онд 19 хууль;
- 2020 онд 7 хууль;
- 2021 онд 38 хууль;
- 2022 онд 99 хууль;
- 2023 онд 21 хуульд нэмэлт өөрчлөлт оруулжээ.

Үүнээс үзвэл, төсвийн хуулийг дагалдуулан нэмэлт өөрчлөлт оруулсан хуулийн тоо сүүлийн жилүүдэд нэмэгдэж байна. Тухайлбал, Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийг өргөн барихад Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг иш татаж, зайлшгүй шаардлагатай хэмээн 38 хуульд өөрчлөлт оруулах саналыг дагалдуулсан байдаг.

Мөн Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн төслийг 2021 оны 10 сарын 14-ний өдөр УИХ-д өргөн барихад “Монгол Улсын Засгийн газар “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт үндэслэн¹⁴” 110 хууль дагалдуулж өргөн мэдүүлсний 99 нь УИХ-аар батлагдсан

байна.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийг дагалдан Төрийн хяналт шалгалтын тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлт нь Засгийн газрын бүрэлдэхүүн өөрчлөгдсөний дараа батлагджээ. Түүнчлэн Улсын Их Хурлын 2020 оны сонгуулийн дараагийн 2 жилд төсвийн хуулийг дагалдан 38 болон 99 хуульд тус тус нэмэлт өөрчлөлт орсон байна.

Хууль тогтоомжийн тухай хуульд 2023 оны 05 сарын 04-ний өдөр орсон нэмэлт өөрчлөлтөөр анхдагч хуулийн болон шинэчилсэн найруулгын төслийг дагалдах хуулийн горимоор батлахыг хоригложээ.¹⁵ Гэвч уг шаардлага нь Төсвийн тухай хуулийн дагалдах хуульд хамаарах эсэх нь ойлгомжгүй байна. Үүнийг энэхүү тайлангийн анхдагч хуулийн төсөлтэй холбоотой хэсэгт дэлгэрэнгүй авч үзэх болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн Гуравдугаар бүлэгт хуулийн төслийг хэлэлцэн батлах журмыг тогтоосон. Тус журмын дагуу хуулийн төсөл хэлэлцэх УИХ-ын чуулганы хэлэлцүүлэг нь дараах үе шатаар явагдана.¹⁶

1. Хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг;
2. Хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг;
3. Хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэг;
4. Хуулийн төслийг эцэслэн батлах хэлэлцүүлэг.

Тэрчлэн аливаа хуулийн төслийг УИХ-ын холбогдох байнгын хороо заавал хэлэлцэж, санал, дүгнэлт гарган чуулганы нэгдсэн хуралдаанд бэлтгэх ёстой.¹⁷ Харин төсөв, түүний гүйцэтгэлийг хэлэлцэх журмыг уг хуулийн Наймдугаар бүлэгт тусгайлан зохицуулсан. Улсын төсвийг хэлэлцэх үе шат:

1. Төсвийн төслийн нэг дэх хэлэлцүүлэг буюу төсвийн төслийг нэгдсэн хуралдаанд танилцуулах;
2. Төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлэг буюу төсвийн төсөлд өөрчлөлт оруулах санал, дүгнэлт гаргах;
3. Төсвийн төслийн гурав дахь хэлэлцүүлэг буюу төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийн үр дүнг танилцуулах;

¹⁴ Монгол улсын Ерөнхий Сайдын 2021 оны 10 сарын 14-ний өдөр УИХ-ийн чуулганд хэлсэн үгнээс <https://cabinet.gov.mn/5555.html>

¹⁵ Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг

¹⁶ Монгол улсын их хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсэг

¹⁷ Монгол улсын их хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 35 дугаар зүйл

4. Төсвийн төслийн дөрөв дэх хэлэлцүүлэг буюу төсвийн төслийг эцэслэн батлах.¹⁸

Дээрхээс үзвэл тухайн жилийн төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлэгдсэн хуулийн төслүүд нь байнгын хорооны санал дүгнэлтгүй, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх эсэх нь урьдчилан шийдэгдэхгүйгээр (төсвийн тухай хуулийн төслийн багцад хамаарч) чуулганд шууд танилцуулагдаж байна.

Хууль тогтоомжийн тухай хууль батлагдсанаас хойш 2022 он хүртэл тухайн жилийн төсвийн тухай хуулийг дагалдуулан анхдагч хуулийн төсөл батлагдаж байгаагүй. Харин 2023 оны төсвийг батлахад Засгийн газар дахь хяналтын тухай, Төрийн хэмнэлтийн тухай зэрэг анхдагч хуулийг баталжээ. Төсвийн тухай хуультай хамт баталсан Засгийн газар дахь хяналтын тухай хуулийг дагалдуулан 82 хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, мэргэжлийн хяналтын чиг үүргийг холбогдох төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагад шилжүүлсэн байна.

А.Төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулж байгаа тухайд

Жил бүр төсвийн тухай хуулийг батлахад Улсын Их Хурлаас баталсан дараа оны төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж иржээ.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.9-д “дунд хугацаа” гэж дараа жилийн болон түүний дараах дараалсан хоёр жилийг хамарсан төсвийн гурван жилийг; мөн зүйлийн 4.1.10-д “дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл” гэж тухайн төсвийн жилийн хүлээгдэж байгаа макро эдийн засгийн болон төсвийн гүйцэтгэлийн төлөв байдал, дунд хугацааны макро эдийн засгийн ба төсвийн үндсэн үзүүлэлтийн төсөөлөлд суурилсан төсвийн бодлогын баримт бичгийг хэлнэ гэж заасан байдаг. Үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-д “Улсын Их Хурал төрийн дотоод, гадаад бодлогын аль ч асуудлыг санаачлан хэлэлцэж болох бөгөөд дараах асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ” гээд уг зүйлийн 7 дахь хэсэгт “төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлого, үндсэн чиглэлийг тодорхойлж, хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцүүлэн боловсруулсан Засгийн газрын үйл ажиллагааны

Өөрөөр хэлбэл, Төсвийн тухай хуулийн дагалдах хуулийг дагалдуулан өөр бусад хуульд өөрчлөлт оруулсан гаж тохиолдол гарчээ. Ийнхүү Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуультай хамт батлагдсан анхдагч хууль, түүнийг дагалдсан 82 хуулийн нэмэлт өөрчлөлт нь холбогдох байнгын хорооны санал, дүгнэлтгүй, Хууль тогтоомжийн тухай хуульд заасан тооцоо, судалгаа, олон нийтийн хэлэлцүүлэггүйгээр батлагджээ.

Ер нь сүүлийн 7 жилийн төсвийн хуультай хамт батлагдсан хуулиуд болон сүүлийн 2 жилийн төсвийн тодотголын хамт өргөн мэдүүлэгдсэн хууль тогтоомжууд нь бүгдээрээ холбогдох байнгын хорооны санал, дүгнэлтгүйгээр батлагдсан байна. Иймд жил бүр төсвийн тухай хуулийг дагалдуулан олон тооны хууль тогтоомжид өөрчлөлт оруулж буй явдлыг анхаарах, нэн ялангуяа дараах асуудлуудыг нарийвчлан судалж, нэг мөр ойлголт, хууль хэрэглээний зөв практик тогтоох нь зүйтэй.

хөтөлбөр, улсын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг батлах” асуудлыг тусгажээ. Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 25.7-д “...Хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байна. Улсын төсвийг хэлэлцэн батлахдаа төсвийн орлого, зарлагын бүтцийг өөрчилж болно. Ингэхдээ Засгийн газрын өргөн мэдүүлсэн төсвийн зарлагын болон алдагдлын хэмжээг нэмэгдүүлж үл болно” гэж заасан нь Монгол Улсын нийгэм, эдийн засгийн бодлогын уялдаа холбоо, залгамж чанар, нэгдмэл байдлыг хангахад чухал ач холбогдолтой юм. Үндсэн хуульд оруулсан энэхүү нэмэлт, өөрчлөлтийн үзэл санаа нь Улсын Их Хурал улсын хэмжээний хөгжлийн бодлогыг санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлоготой хамт, нөгөө талаас үндэсний аюулгүй байдлын бодлогыг тус тус тодорхойлон баталж, түүнийг хөгжлийн дунд болон богино хугацааны баримт бичиг болох Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсвөөр дамжуулан хэрэгжүүлэх агуулгатай байна. Түүнчлэн энэхүү баримт бичгийн гүйцэтгэлийн тайланд хяналт тавих Улсын Их Хурлын эрхийг баталгаажуулсан байна. Үүнийг бодлого, түүнийг хэрэгжүүлэх төсөв, санхүүгийн эх үүсвэрийг баталж, эргээд зарцуулалтад хяналт тавих тасралтгүй үйл явц хэмээн ойлгож болно. Улсын хөгжлийн бодлогыг тодорхойлох, төлөвлөлт хийх үйл явц нь Улсын

¹⁸ Төсвийн тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.1 дэх хэсэг

Их Хурлын үндсэн чиг үүрэг болох хууль тогтоох, хянан шалгах чиг үүргийн харилцан шүтэлцээнд оршиж байна.

Үндсэн хуулийн дээрх нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн Улсын Их Хурлаас 2020 онд Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан. Уг хуульд хөгжлийн бодлого, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөлтийн баримт бичгүүдийн төрлийг дараах байдлаар тодорхойлжээ.

Хөгжлийн бодлогын баримт бичигт:

- Урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа”;
- Хөгжлийн зорилтот хөтөлбөрийг ойлгоно.

Хөгжлийн төлөвлөлтийн баримт бичигт:

- Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл;
- Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл;
- Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр;
- Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр;
- Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө;
- Улсын төсөв, аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө;
- Орон нутгийн төсөв тус тус багтана.

Үүнээс улсын төсөв нь хөгжлийн бодлогын баримт

Б. Монгол Улсын Засгийн газар, харьяа байгууллагын бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулж буй тухайд

Монгол Улсын жилийн төсвийг хэлэлцэн батлахтай холбогдуулан Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, төрийн захиргааны төв болон бусад байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт оруулах тохиолдол их байна. Үүнд төрийн гүйцэтгэх чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан шинээр байгуулах болон аль нэг төрийн байгууллагын чиг үүргийг өөр байгууллагад шилжүүлэхтэй холбоотой өөрчлөлт зонхилж байна. Төрийн аливаа байгууллагын чиг үүрэг нь тухайн салбарын хууль тогтоомжид тусгагдсан байдаг тул тэдгээрийн бүтцэд өөрчлөлт оруулах нь тэр хэмжээгээрээ олон хуульд зэрэг өөрчлөлт оруулах шаардлага үүсгэнэ. Тухайлбал, 2017 онд эрүүл мэндийн даатгалын байгууллага гэсэн хэрэгжүүлэгч агентлагийг шинээр байгуулсантай холбоотойгоор Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 56 хэсэг, заалтад өөрчлөлт оруулж байв.

бичгийг хэрэгжүүлэх богино хугацааны хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг¹⁹ бөгөөд Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх шаардлага тавигддаг байна.

Түүнчлэн 2021 онд Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр Засгийн газар Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг жил бүрийн 05 дугаар сарын 01-ний дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх ба Улсын Их Хурал 06 дугаар сарын 01-ний дотор батлахыг хуульчилжээ.²⁰ Ийнхүү өмнө нь Улсын Их Хурал 07 дугаар сарын 01-ний дотор баталдаг байсныг 06 дугаар сарын 01-ний өдөр болгон өөрчилсөн нь төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөллийн тухай хуулийг батлах хугацаатай нийцүүлэх шаардлагад үндэслэсэн болно. Энэ нь мөн л улсын төсөв нь хөгжлийн бодлоготой нийцсэн, түүнийг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх зохицуулалттай холбоотой.

Үүнээс дүгнэхэд төсвийн дунд хугацааны төлөвлөлт болох Төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөллийн тухай хуулийг Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй нийцүүлэн батлах шаардлагатай боловч жил бүр төсвийн тухай хуулийг дагуулан өөрчлөлт оруулж байгаа нь тэдгээрийг урьдчилан баталж байгаагийн ач холбогдлыг алдагдуулж байна.

Тэрчлэн 2022, 2023 оны төсвийн тухай хуулийг дагаж Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, төрийн захиргааны байгууллагын тогтолцоонд хэд хэдэн өөрчлөлт оржээ. Тодруулбал, 2021 онд Эдийн засаг, хөгжлийн яам, Цахим хөгжил, харилцаа холбооны яамыг шинээр байгуулсантай холбоотойгоор Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 18 зүйл, хэсгийг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 31 хэсэг, заалтыг, Харилцаа холбооны тухай хуулийн 13 хэсэг, заалтыг тус тус өөрчилжээ.

Мөн 2021 онд боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагыг байгуулах, хилийн мэргэжлийн хяналтын чиг үүргийг гаалийн байгууллагад шилжүүлсэн зэрэг төрийн байгууллагын бүтэц, чиг үүрэгтэй холбоотой томоохон өөрчлөлт хийгдсэн юм. Үүнтэй холбоотойгоор 15 хуульд өөрчлөлт оруулах

19 Ц.Баянмөнх, “Бодлогын шийдвэр, төлөвлөлт, төсөвлөлтийн уялдааг хангах нь: Эрх зүйн зохицуулалт, хэрэгжилт” эрдэм шинжилгээний өгүүлэл.

20 Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 18.3 дахь хэсэг

шаардлага үүсжээ. Энэ өөрчлөлт нь цаашид мэргэжлийн хяналтын бие даасан тогтолцоо байх эсэх асуудлыг хөндсөнөөр 2023 оны төсвийн тухай хуулийг дагаж Төрийн хяналт шалгалтын тухай хууль болон холбогдох 82 хуульд өөрчлөлт орж, мэргэжлийн хяналтын нэгдсэн тогтолцоог татан буулгаж салбар бүрд хариуцуулсан байна. Мөн 2023 оны төсвийн хуулиар Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрыг шинээр байгуулан ажиллуулж байна.

Эдгээр өөрчлөлтийг нарийвчилсан тооцоо судалгаанд үндэслэдэггүйгээс олон дахин өөрчлөлт хийж, тэр болгонд хууль тогтоомжийг дахин дахин өөрчлөхөд хүргэдэг. Тухайлбал, 2022 оны төсвийн тухай хуулийг дагаж холбогдох хуульд өөрчлөлт орсноор Эдийн засаг, хөгжлийн яамыг байгуулсан бол дөнгөж нэг жилийн дараа буюу 2023 оны төсвийн тухай хуулийг дагаж Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын бүтцийн тухай, Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулиудыг өөрчилж, Монгол Улсын шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд болгон өөрчилсөн байна. Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний “Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг” гэсэн хэсэгт “Хөрөнгө оруулалт, худалдааны газар” гэж, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний “Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг” гэсэн хэсэгт “Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар” гэж нэмж, хоёр агентлаг шинээр байгуулсан байна. Гэвч үүнээс 7 сарын өмнө 2022 оны төсөвт тодотгол хийх үед Засгийн газраас Хөрөнгө оруулалт, худалдааны асуудал хариуцсан хэрэгжүүлэгч агентлагийг байгуулахаар өргөн мэдүүлж байсан ч түүнийг шаардлагагүй гэж үзэж хууль санаачлагчид нь буцааж байсан ажээ. Тэрчлэн 2021 онд хүүхэд харах үйлчилгээний асуудлыг нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад шилжүүлсэн бол мөн онд хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан Засгийн газрын гишүүний эрхлэх асуудалд шилжүүлжээ.

Түүнээс гадна төсвийн хуулийг дагаж 2021 онд Улсын Их Хурлын “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” Улсын Их Хурлын 2020 оны 07 дугаар тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулж, Ойн газар гэсэн Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагийг байгуулсан бол

2022 онд 2023 оны төсвийг батлахад Боомтын асуудал эрхэлсэн, Олимпизм, нийтийн биеийн тамирын асуудал эрхэлсэн, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах асуудал эрхэлсэн сайдын албан тушаалыг бий болгосон байна.

Үүнээс үзэхэд сүүлийн хоёр жилийн хугацаанд төсвийн хуулийг дагаж Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн болон төрийн захиргааны байгууллагын тогтолцоонд ойр ойрхон олон удаагийн өөрчлөлт орсон байна.

Хамгийн гол нь Засгийн газар, түүний харьяа төрийн захиргааны байгууллагын бүтэц бүрэлдэхүүнийг өөрчлөх, чиг үүргийг нэгээс нөгөөд шилжүүлэх, нэгтгэх тусгаарлах асуудал нь төсвийн тухай хуулийг дагалдан хийгдэж байгаа нь асуудал дагуулж байна. Учир нь өмнө дурдсанчлан энэ нь дагалдах хуулийн ойлголт нь төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэхтэй зайлшгүй холбоотой бөгөөд түүнтэй уялдсан байх шаардлагад нийцэхгүй ба төсвийн тухай хуулийн дагалдах хууль нэрийн дор агуулгын хувьд илүү өргөн хүрээтэй өөрчлөлт хийх, салбарын болон салбар дундын асуудлуудыг нэг зохицуулалтаар зохицуулах гэсэн шинжтэй байгаа нь төсвийн тухай хуулийн дагалдах хуулийн ойлголтод үл хамаарах шинжтэй гэж үзэж болохоор байна.

Өөрөөр хэлбэл, Засгийн газрын бүтэц болон засгийн газрын харьяа төрийн захиргааны байгууллагын бүтэц бүрэлдэхүүнийг өөрчлөх, чиг үүргийг нэгээс нөгөөд шилжүүлэх, нэгтгэх тусгаарлах асуудлыг зохицуулах хууль тогтоомжийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т заасан тооцоо судалгаа үл шаардах хуулийн төслийн жагсаалтад хамаарахгүй. Тодруулбал, Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.8-д “Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний тухай”²¹, 12.2.21-т “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч батлах” гэж заасан нь нэг захиргааны байгууллагын чиг үүргийг байхгүй болгож, нөгөө байгууллагад шилжүүлэх, нэгтгэх, тусгаарлах асуудлуудад хамаарч байна. Иймд Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, төрийн захиргааны байгууллагын тогтолцоонд өөрчлөлт оруулах үндэслэлийг тооцоо судалгаанд тулгуурлан тодорхойлох нь зүйтэй. Ийнхүү тооцоо судалгаагүй өөрчлөлт хийж байгаагийн үр дагавар нь сүүлийн гурван жилийн хугацаанд Засгийн газрын бүтцэд 6 удаа өөрчлөлт оруулсан ба зарим байгууллагын бүтцэд оруулсан өөрчлөлтийг дараагийн жил нь буцаан

21 2023 оны 05 сарын 04 өдрийн нэмэлт өөрчлөлтөөс өмнөх зохицуулалт

өөрчилсөн зэргээс тод харагдаж байна.²²

В. Төсвийн тухай хуулийг дагалдуулан анхдагч хууль баталсан тухайд

Хууль тогтоомжийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-д “Хууль санаачлагч нийгмийн харилцааны төлөв байдал, тулгамдсан асуудлыг судалсны үндсэн дээр шинээр үүссэн харилцааг хуулиар зохицуулах шаардлагатай, эсхүл тухайн нийгмийн харилцааны эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан шинэ хуулиар зохицуулах шаардлагатай гэж үзвэл анхдагч хуулийн төсөл боловсруулна” гэж заасан. Мөн хуулийн 13 дугаар зүйлийн 13.3-т “Хууль санаачлагч хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгааг анхдагч хуулийн төсөл болон хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуульд зарчмын шинжтэй зохицуулалт шинээр нэмж оруулж байгаа хуулийн төслийг боловсруулахад хийнэ” гэжээ.

Хуулийн төслийг хэлэлцэх талаар Улсын Их Хурлын чуулганы дэгд өөрөөр заагаагүй бол зохих байнгын хороогоор хэлэлцэж, санал дүгнэлт гаргах шаардлага тавигддаг.

Дээрхээс дүгнэж үзвэл, төсвийн тухай хуулийг дагалдуулан анхдагч хуулийн төсөл боловсруулж байгаа бол Хууль тогтоомжийн тухай хуульд заасан бичвэр болон хэлбэр, процессын нийтлэг шаардлагаас гадна дараах үндсэн процессын шаардлагыг баримтлах учиртай.

- Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай байх;
- Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгаа хийсэн байх;
- Холбогдох байнгын хороогоор хэлэлцэгдэж, санал, дүгнэлт гарсан байх.

Энэхүү шалгуурын хүрээнд 2017-2022 онд төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт анхдагч хууль баталсан 2 тохиолдлыг доор шинжлэн авч үзлээ.

Төрийн хэмнэлтийн тухай анхдагч хууль: Уг хуулийн төслийг Монгол Улсын Засгийн газраас Монгол Улсын 2022 оны төсвийн тодотголын хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн бөгөөд Улсын Их Хурал 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр баталсан байна.

Энэ хуулиар төрийн бүх шатанд санхүүгийн

сахилга батыг мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах, хяналт тавих болон улсын салбарт хамаарах аливаа хуулийн этгээдийн зарим үйл ажиллагаанд хэмнэлтийн горимыг хэрэгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэхийг зорьжээ.

Хуулийн үйлчлэлд бүх төрийн албан хаагч, төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, тэдгээрийн албан хаагч, төрийн болон орон нутгийн өмчийн 50 болон түүнээс дээш хувийн оролцоотой хуулийн этгээд, мөн бүх шатлалын төсөв, тусгай сан, төсөвт авсан зээл, тусламжийн эх үүсвэр хамаарна. Үүнээс харахад уг хуулийн төсөл нь төсвийн хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой байх шаардлагад нийцсэн гэж үзэж болохоор байна.

Харин анхдагч хуулийн төсөл боловсруулахад тухайн асуудлыг хуулиар зохицуулах хэрэгцээ шаардлагыг тандан судалсан байх шаардлагыг үл харгалзандагалдахуульнэрээржмарнэгэнтооцоо, судалгаагүйгээр, буюу хэрэгцээ шаардлагыг тодорхойлолгүй, үзэл баримтлалгүйгээр төслийн танилцуулга хэлбэрээр төсвийн хуулийг дагалдуулж баталсан байна. Ялангуяа анхдагч болон шинэчилсэн найруулгын төслийг дагалдах хууль байдлаар баталсан нь хууль тогтоомжийн тухай хуулийг зөрчсөн гэж үзэж болохоор байна.

Хууль тогтоомжийн тухай хуульд 2023 оны 5 дугаар сарын 04-ний өдөр өөрчлөлт оруулж, 14 дүгээр зүйлийн 14.4, 14.5 болон 29 дүгээр зүйлийн 29.3-ыг нэмсэн байна. Эдгээр нэмэлт нь нэг салбарын хуулийг багцлах тухай асуудал бөгөөд тухайн салбарын ерөнхий хуулийг дагалдуулан салбарын харилцааг зохицуулах анхдагч хууль, эсхүл хуулийн шинэчилсэн найруулгыг өргөн мэдүүлэх гэж ойлгогдож байна. Гэвч энэхүү зохицуулалт 2022 онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийг батлах үед хуульд тусаагүй байсныг анхаарах нь зүйтэй.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан чуулганы нэгдсэн хуралдааны нийтлэг журмын дагуу Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгд өөрөөр заагаагүй бол нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг зохих байнгын хороо урьдчилан хэлэлцэж санал,

²² Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай УИХ-ийн тогтоол 2020.08.28-ний өдөр батлагдаж түүнээс хойш 2021.11.12, 2022.11.11, 2022.12.23, 2023.06.16, 2023.07.07, 2023.07.07-ний өдрүүдэд нийт 6 удаа өөрчлөлт орсон байна.

дүгнэлт гаргана.²³ Тэрчлэн байнгын хороо нь эрхлэх асуудлынхаа хүрээнд хууль санаачлагчаас өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг урьдчилан хэлэлцэж санал, дүгнэлт гарган нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэх, Улсын Их Хурлын хяналтыг хэрэгжүүлэх, хуульд тусгайлан заасан асуудлаар Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулах чиг үүрэгтэй.²⁴

Байнгын хороо анхдагч болон хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцэхдээ шинэ бүлэг, зүйл, хэсэг, заалт нэмэх, эсхүл өргөн мэдүүлсэн хуулийн төслөөс холбогдох бүлэг, зүйл, хэсэг, заалтыг хасах, бүтэц, найруулга, үг хэллэгийг өөрчлөх, засварлах тухай санал, дүгнэлт гаргана²⁵ гэж зохицуулсан бөгөөд анхдагч болон шинэчилсэн найруулгын төслүүдийг байнгын хороогоор хэлэлцдэг. Харин энэ тохиолдолд аливаа хууль тогтоомжийн төслийг холбогдох байнгын хороогоор урьдчилан хэлэлцэж, санал дүгнэлт гаргах шаардлага зөрчигджээ.

Засгийн газар дахь хяналтын тухай хууль: Төсвийн тухай хуулийн төслийг дагалдуулж томоохон анхдагч хуулийн төслийг өргөн мэдүүлж батлуулсан удаах тохиолдол нь энэ юм. Уг хуулийг өмнөх хуулийн нэгэн адил 2023 оны Төсвийн тухай хуулийн танилцуулгад Гүйцэтгэх засаглал дахь хяналтын тухай хуулийн төслийн

танилцуулга байдлаар Улсын Их Хуралд өргөн мэдүүлж батлуулжээ.

Энэ хууль батлагдсанаар гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага, тэдгээрийн удирдах болон гүйцэтгэх албан тушаалтны үйл ажиллагаанд хуулийн хэрэгжилтийг хангуулах, хууль ёсыг сахиулах, сахилга, хариуцлагыг дээшлүүлэх, бүтээмжийг нэмэгдүүлэх, Засгийн газраас харьяа байгууллага, албан тушаалтанд хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх замаар Монгол Улсын хууль тогтоомж бүрэн хэрэгжих, иргэний эрх, эрх чөлөө баталгаатай хангагдана гэж үзэж уг анхдагч хуулийг баталсан байна.

Харин энэ хуулийг заавал төсвийн тухай хуультай хамт өргөн мэдүүлэх буюу тухайн жилийн төсвийн хуулийг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай эсэх тухай нотолгоо бүрхэг байна. Тэрчлэн төрийн байгууллага, албан тушаалтны хууль бус шийдвэр, үйл ажиллагааны улмаас зөрчигдсөн хүний эрх, эрх чөлөөг сэргээн тогтоолгох гомдол, хүсэлт гаргах харьяалал, дэс дараалалд өөрчлөлт оруулах үр дагавар бүхий дээрх хуулийн төслийг хэрэгцээ шаардлага, үр дагавар, ялангуяа хүний эрхэд үзүүлэх нөлөөллийг үнэлж тооцолгүй, холбогдох байнгын хорооны санал дүгнэлтгүйгээр баталсан нь анхаарал татаж байна.

Г. Дагалдах хууль нэрийн доор хууль тогтоомжид зарчмын шинжтэй томоохон өөрчлөлт оруулсан тухайд

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн дагалдах хуулийн хүрээнд зарим хууль тогтоомжид зарчмын шинжтэй томоохон өөрчлөлт оруулсан нь Төрийн хяналт шалгалтын тухай хуульд оруулсан нэмэлт өөрчлөлт байв.

Энэ нь хэдийгээр нэг байгууллагыг татан буулгаж, чиг үүргийг нь салбарын яамдад шилжүүлж байгаа ч Монгол Улсад 20 орчим жил хэрэгжсэн мэргэжлийн хяналтын нэгдсэн тогтолцоог татан буулгах хэрэгцээ шаардлага, үр дагаврыг маш сайн тооцоо, судалгаатайгаар авч хэлэлцэх шаардлагатай байсныг анхаарах ёстой.

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн хүрээнд мэргэжлийн хяналтын байгууллага 26 төрлийн хяналт, бусад 12 байгууллага өөрийн эрхлэх асуудлын хүрээнд холбогдох хяналт хэрэгжүүлж ирсэнээс гадна татвар, гааль, цагдаа, оюуны өмч, гадаадын иргэн, харьяатын асуудал болон өрсөлдөөн, хэрэглэгчийн эрхийн асуудал

хариуцсан төрийн захиргааны байгууллагууд холбогдох салбарын хуулийн дагуу хяналтын чиг үүргийг хэрэгжүүлж байснаас мэргэжлийн хяналтын нэгдмэл тогтолцоо алдагдсан гэж үзсэн байдаг. Иймд төрийн байгууллагуудын хяналтын чиг үүргийн давхардлыг арилгах, мэргэжлийн хяналтын үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах зорилгоор төрийн хяналт шалгалтын чиг үүргийг салбарын яам, агентлаг, мэргэжлийн байгууллагад шилжүүлэх шаардлага бий болсон гэж үзэж Засгийн газраас уг хуулийн төслийг боловсруулжээ.

- Хяналтын тогтолцоонд дараах зарчмын шинжтэй томоохон өөрчлөлтийг уг хуульд оруулжээ. Үүнд:
- Хяналт шалгалтын шинэ төрөл буюу сэргийлэх хяналт шалгалт бий болгосон;
- Төрийн захиргааны төв байгууллагын хяналт шалгалтын чиг үүргийг мэргэжлийн

23 Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.11 дэх хэсэг

24 Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг

25 Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэг

- байгууллагад шилжүүлэх боломж бүрдүүлсэн;
- Бүх шатны Засаг дарга Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу хяналт шалгалтын чиг үүргийг хэрэгжүүлэх;
 - Хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий төрийн захиргааны төв байгууллага жил бүр хяналт шалгалтын төлөвлөгөө гаргаж Засгийн газраар батлуулах.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3-т хуулийн төсөл санаачлагч нь “шаардлагатай тохиолдолд” бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулна” гэж заасан. Үүнийг дагалдах хуулийн төсөл боловсруулах гол үндэслэл гэж үзэж болохоор байна. Хэдийгээр “шаардлагатай тохиолдол” гэдгийг нарийн тодорхойлоогүй боловч хууль тогтоомжийн зөрчил хийдэл үүсэхээс сэргийлэхийн тулд нэр томъёо болон зүйл, заалтын дугаарыг уялдуулах, өргөн баригдаж байгаа хуулийг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай зохицуулалтыг холбогдох хуульд тусгах гэсэн агуулгатай. Үүнээс харахад ямар нэг хуулийн үзэл баримтлалыг өөрчлөх буюу зарчмын шинжтэй томоохон өөрчлөлт үүнд хамаарахгүй гэж үзэж болно.

Өөрөөр хэлбэл, тухайн хуулийн үзэл баримтлал өөрчлөгдөхөд хүргэх эсхүл хуулийн нийт заалтын 50-аас дээш хувьд нэмэлт өөрчлөлт оруулах бол шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах учиртай. Шинэчилсэн найруулгын төслийг нэг салбарын харилцааг зохицуулахад харилцан уялдуулах шаардлагатайгаас бусад тохиолдолд дагалдах хууль байдлаар өргөн мэдүүлж болохгүй. Тэрчлэн шинэчилсэн найруулгын төсөлд хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийсний үндсэн дээр гарч байгаа хүндрэл бэрхшээл, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг тодорхойлж, хамгийн зохистой шийдлийн хувилбарыг тодорхойлсон байх шаардлагатай.

Харин тухайн жилийн төсвийн тухай хуулийг дагалдуулан Төрийн хяналт шалгалтын тухай

хуульд оруулсан зарчмын шинжтэй томоохон өөрчлөлт нь шинэчилсэн найруулга бус нэмэлт өөрчлөлтийн хэлбэртэй байгааг анхаарах нь зүйтэй.

Ийнхүү мэргэжлийн хяналтын чиг үүргийг татан буулгаж, төрийн захиргааны байгууллагуудад шилжүүлэх зарчмын томоохон өөрчлөлтийг тухайн жилийн төсвийн тухай хуулийг дагалдуулан хийж байгаа нь хуулийн бие даасан үзэл баримтлал, хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, олон нийтийн хэлэлцүүлэг хуулийн төсөл, түүнийг боловсруулахад тавих шаардлагыг зөрчсөн байна. Тэрчлэн төрийн хяналт шалгалтын тухай хуулийг шинэчлэн баталсан нь төсвийн тухай хуулийн дагалдах хуульд хамаарах эсэх асуудал маргаан дагуулж байна.

Энэ байдлыг залруулахад чиглэсэн зохицуулалт 2023 оны 5 дугаар сарын 04-ний өдөр Хууль тогтоомжийн тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр бий болжээ. Тухайлбал, Хууль тогтоомжийн тухай хуулийн 14.4-т “Хууль санаачлагч тодорхой салбарын хоорондоо уялдаатай хэд хэдэн хуулийн төслийг нэгэн зэрэг хамтад нь хэлэлцүүлэхээр багцлан боловсруулж, өргөн мэдүүлж болно.”, 14.5-д “Энэ хуулийн 14.4-т заасны дагуу хэд хэдэн хуулийн төслийг багцлан боловсруулахдаа тухайн харилцааг зохицуулж байгаа ерөнхий хуулийг дагаж анхдагч хуулийн төсөл боловсруулах, шинэчлэн найруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд төсөл тус бүрийн агуулгыг нэгтгэн нэг үзэл баримтлалаар тодорхойлж болно” гэсэн бол мөн хуулийн 29.4-т “Энэ хуулийн 14.5-д зааснаас бусад хуулийн төслийг дагалдуулан анхдагч болон шинэчилсэн найруулгын төслийг өргөн мэдүүлэхийг хориглоно” гэсэн хэсгийг 2023 оны 5 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар нэмсэн байна.

Харин 2022 онд Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулахад дээрх зохицуулалт байгаагүй тул хуулиар зохицуулаагүй байдлыг ашиглан хүч түрэн шийдвэрлэснийг 2023 оны хуулийн өөрчлөлтөөр нөхөж зохицуулах нь зөв эсэхийг анхаарах нь зүйтэй.

ЗАРИМ УЛСЫН ТУРШЛАГААС

Бүгд Найрамдах Солонгос Улс

Бүгд Найрамдах Солонгос Улс (БНСУ) нь төсөв батлах үйл явцыг Үндэсний санхүүгийн тухай хуулиар зохицуулдаг.²⁶ Тус хуулийн 7 дугаар

зүйлийн 7.1-т зааснаар Засгийн газар улсын дунд хугацааны төсвийн төлөвлөгөөг таваас доошгүй жилээр төлөвлөн Үндэсний Ассамблейд

26 National finance act 2021.

оруулж батлуулах ба жил бүрийн төсвийн төслийг дараагийн төсвийн жил эхлэхээс 120 хоногийн өмнө Ерөнхийлөгчид өргөн мэдүүлж батлуулсны дараа Үндэсний ассамблейд өргөн мэдүүлдэг байна.²⁷ Тухайн жилийн төсвийн тухай хуулийн төсөл боловсруулахад тавих шаардлагыг Үндэсний санхүүгийн тухай хуулийн 34 дүгээр зүйлд тодорхойлжээ. Үүнд “улсын төсвийн дагалдах баримт бичиг” –ийг тусгайлан хуульчилсан байх бөгөөд нийт 16 төрлийн баримт бичгийг хавсаргаж хамтад нь өргөн мэдүүлэх боловч улсын төсвийг дагалдуулж өөр хуульд өөрчлөлт оруулах талаар тухайлан дурдаагүй ажээ.²⁸

Харин Үндэсний ассамблейн тухай хуулиар улсын төсвийг хэрхэн өргөн мэдүүлэх, тусгай болон байнгын хороодоор хэлэлцүүлж дүгнэлт гаргах, ялангуяа хууль зүйн тусгай хороогоор бүтэц, найруулгын хяналт заавал хийлгэх, олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулах зэрэг шаардлага тавьжээ.

Үндэсний ассамблейн тухай хуульд зааснаар улсын төсвийн төслийн бүрдэлд тухайн жилийн улсын төсөв, улсын сангуудын үйл ажиллагааны төлөвлөгөө, улсын данс, тэдгээрийн өглөг, авлага, тооцооны асуудлууд багтах бөгөөд Үндэсний ассамблейн дэргэдэх Төсөв, санхүү хариуцсан тусгай хороо нь төсвийн хуулийн төсөлд хавсаргасан хуулийн төслүүдийг төсвийн орлогын тооцоолсон дүнгээр жил бүрийн 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор шалгаж дүгнэлт гаргадаг ажээ.²⁹

Өөрөөр хэлбэл, төсвийн хуулийг хавсаргасан хуулийн төслийн агуулгад тухайн жилийн орлого зарлагыг хангах, сангуудын үйл ажиллагааны

төлөвлөгөөг хангах зорилгод нийцсэн байх шаардлага тавигддаг байна. Улмаар төсөв, санхүү хариуцсан тусгай хороо дагалдах хуулиуд нь дээрх зорилгод нийцсэн гэж үзвэл Үндэсний ассамблейн тухай хуулийн 85.3.2-т заасны дагуу бүтэц, найруулгыг хянуулахаар хууль зүйн тусгай хороонд хүргүүлнэ.

Ийнхүү дээр дурдсанчлан төсвийн төслийн багцыг Ерөнхийлөгч баталж, Үндэсний ассамблейд өргөн мэдүүлж холбогдох хороод хянасны дараа Засгийн газар нь холбогдох яамдаас санал авах ба давхар олон нийтээр хэлэлцүүлдэг.³⁰

БНСУ-ын Үндэсний ассамблейгаар хоёр болон түүнээс дээш хуулийг шинэчлэн найруулж батлах бол шинэчлэн найруулж буй хууль тус бүрд үзэл баримтлал боловсруулж, холбогдох судалгаа хийн олон нийтийн хэлэлцүүлэг өрнүүлнэ.³¹ Ердийн хууль тогтоомжийг дагалдуулан өөр бусад хууль батлах, нэмэлт өөрчлөлт оруулах тохиолдолд судалгаа хийж, хэрэгцээ шаардлага, гарах зардал, нийгэмд үзүүлэх нөлөө, хэрэгжих боломж, тухайн хууль батлагдах цагийн үеийн шаардлага бий эсэх гэх мэт зүйлсийг үнэлж тооцсон байх ёстой.³²

Дээрхээс үзвэл, БНСУ-д төсвийн хууль боловсруулах асуудлыг Үндэсний санхүүгийн хуулиар шийдвэрлэж, харин түүний дагалдах хууль, түүнд тавигдах шаардлагыг Үндэсний ассамблейн тухай хуулиар зохицуулж байна. Төсвийн тухай хуулийг дагалдаж батлагдах хуульд тавигдах шалгуур нь тухайн жилийн орлого зарлагыг хангах, сангуудын үйл ажиллагааны төлөвлөгөөг хангах зорилгод нийцсэн байх бөгөөд үүнд Үндэсний ассамблейн Төсвийн бодлогын газар хяналт тавьж буй нь манай улсад ач холбогдолтой байж болох юм.

Бүгд Найрамдах Эстони Улс

Бүгд Найрамдах Эстони Улсын (Эстони Улс) Үндсэн хуулийн 103 дугаар зүйлд заасны дагуу хууль санаачлах эрхийг Ерөнхийлөгч, Засгийн газар, парламентын гишүүд, парламентад суудалтай улс төрийн нам, парламентын хороод эдэлнэ. Ерөнхийлөгч нь зөвхөн Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл санаачилж болно.

Аливаа хууль тогтоомжийн төсөл нь парламентаас баталсан хууль тогтоомжийн техникийн дүрэм болон Засгийн газраас баталсан хууль тогтоомж, техникийн дүрэмд нийцсэн байх ёстой.

Эстони Улсын Засгийн газрын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3-т заасны дагуу Засгийн

27 National finance act. Article 28, 36 (Documents Accompanying Budget Bills), 2021 <https://www.law.go.kr/LSW/eng/engLsSc.do?menuId=2§ion=lawNm&query=national+assembly&x=0&y=0#liBgcolor2>

28 National finance act. Article 34 (Documents Accompanying Budget Bills), 2021 <https://www.law.go.kr/LSW/eng/engLsSc.do?menuId=2§ion=lawNm&query=national+assembly&x=0&y=0#liBgcolor2>

29 National assembly act. Article 85-3.1 (Documents Accompanying Budget Bills), 2021

30 Legislative process in the Korean Assembly: Drafting and Review Standards of Legislative bill. https://www.ifla.org/wp-content/uploads/2019/05/assets/services-for-parliaments/preconference/2016/cho_presentation.pdf

31 National assembly act <https://www.law.go.kr/LSW/eng/engLsSc.do?menuId=2§ion=lawNm&query=national+assembly&x=0&y=0#liBgcolor2>

32 Мөн тэнд

газар нь төрийн эрх барих байгууллагын зохион байгуулалт, үйл ажиллагаа, түүнээс гарах шийдвэрийн төсөлд тавигдах шаардлагыг тодорхойлсон хэм хэмжээ батлах эрхтэй бөгөөд 2012 онд Хууль тогтоох сайн туршлага ба хууль тогтоомжийн төсөл боловсруулах журмыг³³ баталжээ. Уг журмын 33 дугаар зүйлийн 33.4-т “Улсын төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулах зорилгоор Улсын төсвийн тухай хуульд нийцүүлэн тусад нь төсөл санаачилна” гээд 33.5-д “Жил бүрийн улсын төсвийн тухай хуулийн төсөл нь өөр хуульд нэмэлт өөрчлөлт оруулах болон хүчингүй болгох хуулийг агуулж болохгүй” хэмээн тодорхой тусгажээ.

Мөн дээрх журмын 32 дугаар зүйлийн 32.6-д зааснаар аливаа хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, хүчингүй болгох эсхүл шинэчлэн баталж буй хууль нь хууль тогтоомжийн төсөлд тавигдах ерөнхий шаардлагад нийцсэн байхыг шаарддаг байна. Үүнд хуулийн төслийн хэрэгцээ шаардлага, шууд хэрэглэх боломжийг тодорхойлох судалгаа хийх болон үзэл баримтлалтай байх шаардлага багтжээ.³⁴

Гэхдээ Улсын төсвийн тухай хуулиар³⁵ улсын төсвийн төсөл боловсруулах, түүний бүрдэл болон батлах ажиллагааг тусгайлан хуульчилсан байна. Уг хуулиар ч мөн Хууль тогтоох сайн туршлага ба хууль тогтоомжийн төсөл боловсруулах журамд заасантай ижил нэмэлт өөрчлөлт, хүчингүй болгох, шинэчилсэн найруулгын төслийг бусад хуулийг дагалдуулан батлахыг хязгаарлажээ. Засгийн газраас өргөн мэдүүлсэн улсын төсвийн тухай хуулийн төсөлд парламентын гишүүд нэмэлт өөрчлөлт оруулах боломжтой.³⁶ Гэхдээ

ДҮГНЭЛТ

Сайн засаглалын нэг үндсэн шинж болох хууль тогтоомжийн тогтвортой байдал, хэрэгжилт, үр нөлөөг хангахад аливаа хуулийн төслийг нарийн тооцоо судалгаа, тухайн харилцаанд оролцогчдын олон талт санал шүүмжид үндэслэн боловсруулж, сайтар хэлэлцэн батлах явдал юм.

Аливаа хуулийн төслийн агуулга, хэлбэрт тавигдах хууль зүйн болон процессын шаардлагыг Хууль тогтоомжийн тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулиудаар

тус нэмэлт өөрчлөлт нь бусад хууль тогтоомжийн адил судалгаа шинжилгээ болон олон нийтийн хяналт дор буюу хэлэлцүүлэг хийгдэх зэрэг бие даасан хуулийн адил шаардлагыг хангасан байх ёстой.

Дээрх улсуудад төсөв батлахад тусгайлсан процедур мөрддөг нь манай улстай ижил боловч улсын төсвийн бүрэлдэхүүн хэсэг, түүнийг дагалдаж гарах хууль тогтоомж, боловсруулах үе шат зэргийг илүү нарийвчлан зохицуулсан нь онцлог байна. Тухайлбал, БНСУ-ын хувьд төсвийн дагалдах хууль тогтоомжийг бие даасан хуулийн хүрээнд авч үзэхийн хамт тухайн жилийн орлого зарлага, сангуудын үйл ажиллагааны төлөвлөгөөг хангах зорилгод нийцсэн байх шаардлага тавьж байна. Энэ шаардлагыг хангасан эсэхэд Үндэсний ассамблейн Төсвийн бодлогын газар хяналт тавьдаг. Энэхүү туршлага нь манай улсын хувьд төсвийн тухай хуулийн дагалдах хууль нь тухайн жилийн төсвийг хэрэгжүүлэхэд шаардлагатай эсэхийг шалган тогтоодоггүй байдлыг залруулахад ач холбогдолтой байж болох юм.

Харин Эстони улсын хувьд “Хууль тогтоох сайн туршлага ба хууль тогтоомжийн төсөл боловсруулах журамд *“жил бүрийн улсын төсвийн тухай хуулийн төсөл нь өөр хуульд нэмэлт өөрчлөлт оруулах болон хүчингүй болгох хуулийг агуулж болохгүй”* гэж шууд зааснаас гадна Улсын төсвийн тухай хуулиар ч төсвийн тухай хуулийг дагалдуулж аливаа хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, хүчингүй болгох, шинэчилсэн найруулгын төсөл батлахыг хязгаарласан байна.

тогтоосон байна. Гэвч сүүлийн жилүүдэд хууль санаачлагчдын зүгээс дээрх шаардлагыг зөрчин холбогдох судалгаа, олон нийтийн хэлэлцүүлгийг зохих ёсоор хийхгүй байх, дагалдах хууль нэрээр маш олон тооны хуулийг нэгэн зэрэг өөрчлөх, нэг салбарын хууль тогтоомжийг өөрчлөхдөө бусад салбарын эрх зүйн зохицуулалтад зарчмын шинжтэй өөрчлөлт оруулах, эсхүл бүр нийтлэг үйлчлэх суурь хууль тогтоомжийг өөрчлөх, дагалдах хууль нэрийн дор анхдагч хууль, шинэчилсэн найруулгын төсөл батлах

33 Estonian law: rules for good legislative practice and legislative drafting. 2012, <https://www.riigiteataja.ee/en/eli/508012015003/consolide>

34 Estonian law: rules for good legislative practice and legislative drafting. Section 2.1-2., 2012, <https://www.riigiteataja.ee/en/eli/508012015003/consolide>

35 State budget act 2014.

36 State budget act, Article 38.2. 2014.

явдал гарах болов. Энэ байдал нь төсвийн тухай хууль, түүний дагалдах хуульд тод илэрч байна. Тухайлбал, Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийг дагалдуулан 110 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар өргөн мэдүүлсний 99 нь батлагджээ.³⁷ Сүүлийн долоон жилийн хугацаанд төсвийн тухай хуулийг дагалдуулж нийт 207 хуульд нэмэлт өөрчлөлт оруулсны дотор Засгийн газар дахь хяналтын тухай, Төрийн хэмнэлтийн тухай хууль гэсэн хоёр анхдагч хуулийг хэрэгцээ, шаардлагын тандан судалгаагүйгээр баталсан байна.

Ийнхүү аливаа хууль тогтоомжийг батлан гаргахад Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагыг баримтлахгүй байгаа нь үндэсний эрх зүйн тогтолцооны системчлэлийг алдагдуулж, эрх зүйн хийдэл, давхардал, зөрчил үүсгэх эрсдэлтэй юм.

Монгол Улсын холбогдох хууль тогтоомж болон судалгаанд хамрагдсан гадаад улсын туршлагаас үзвэл дагалдах хууль гэдэг ойлголт, тавигдах шаардлага нь тухайн баталж буй хуулийг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай байх гэсэн шинжийг агуулж байна. Гэвч тухайн жилийн төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай гэж үзэн хамт өргөн мэдүүлж буй дагалдах хуулиудын зарим нь төсвийн харилцаанд хэрхэн хамаарах нь тодорхойгүй байна.

Тэрчлэн төсвийн тухай хуулийн дагалдах хууль нь ихэвчлэн нэмэлт өөрчлөлтийн хэлбэртэй байна. Хууль тогтоомжийн тухай хуулийг үзвэл аливаа хуульд оруулах нэмэлт өөрчлөлт нь тухайн хуулийн үзэл баримтлалыг өөрчлөхөд хүргэхүйц зарчмын шинжтэй эсхүл томоохон өөрчлөлт байх учиргүй байна. Гэвч сүүлийн жилүүдэд төсвийн тухай хуулийг дагалдуулан нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн тоо нэмэгдэхийн зэрэгцээ нэмэлт өөрчлөлт нэрийн дор тухайн салбарын харилцааг тэр чигт нь өөрчлөхүйц томоохон өөрчлөлт хийгдэж байна.

Тухайн жилийн төсвийн тухай хуулийг дагалдуулан төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах нь төсвийн тогтвортой байдал болон төсөв өөрөө улсын хөгжлийн дунд хугацааны хөтөлбөрт нийцсэн байх шаардлагыг алдагдуулж байна.

Тухайн жилийн төсвийн хамт төрийн байгууллагын бүтэц, чиг үүрэгт өөрчлөлт оруулах нь бараг хэвшил болжээ. Төрийн байгууллагын чиг үүргээ хэрэгжүүлэх зардлыг төсөвт тусгах

шаардлагыг үгүйсгэхгүй боловч ийм өөрчлөлтийг төсвийн хуулийг дагалдуулан хийх нь холбогдох тооцоо хийх шаардлага үйлчлэхгүйд хүргэж байна. Тооцоо судалгаагүй байдал нь тухайн шийдвэрийн оновчтой байдалд сөргөөр нөлөөлж, зарим байгууллагын бүтэц, чиг үүрэг жил дараалан эргэж буцан өөрчлөгдөхөд хүргэж байна.

Тухайн хуулийн төсөлд ямар тооцоо судалгаа хийх шаардлагатайг түүний төрлөөс хамааран тогтооно. Өөрөөр хэлбэл, анхдагч хуулийн төсөл бол хэрэгцээ, шаардлагын тандан судалгаа, харин шинэчлэн найруулга эсхүл нэмэлт өөрчлөлтийн төсөл бол хуулийн хэрэгжилт, үр дагаврын үнэлгээг хуулийн төсөл боловсруулж эхлэхээс өмнө хийх ёстой. Тэрчлэн хуулийн төслийг боловсруулсны дараа түүний нийгэмд үзүүлэх үр нөлөөг заавал үнэлж, гарах зардлыг тооцох учиртай. Гэхдээ дээрх шаардлагад хамаарахгүй тохиолдол байхыг үгүйсгэхгүй бөгөөд түүнийг Хууль тогтоомжийн тухай хуулиар нэрлэн тодорхойлсон байдаг. Тухайлбал, төсвийн хууль тогтоомж нь энэ шаардлагад хамаардаггүй учраас түүнтэй хамт өргөн барьсан хуулиуд бүгдээрээ ямар нэг тооцоо судалгаагүйгээр батлагддаг болно. Харин сүүлийн жилүүдэд Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, тооцоо судалгаагүйгээр батлах хууль тогтоомжийн төрлийг улам бүр өргөжүүлсээр байгаа нь анхаарах асуудал болж байна.

Сүүлийн жилүүдэд төсвийн хуулийг дагалдуулан шинэ буюу анхдагч хууль батлах, аль нэг хуульд зарчмын шинжтэй томоохон өөрчлөлт оруулах тохиолдол хэд хэд гарчээ. Тухайлбал, Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулийг дагалдуулан Засгийн газар дахь хяналтын тухай, Төрийн хэмнэлтийн тухай хууль гэсэн 2 шинэ хууль баталснаас гадна Төрийн хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулсан нь мэргэжлийн хяналтын тогтолцоог үндсээр нь хөндсөн томоохон өөрчлөлт болжээ. Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн өөрчлөлтөд нийцүүлэн 99 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан нь дагалдах хуулийг дагалдуулан хууль баталсан “гаж” тохиолдол болсон байна.

Энэ нь Хууль тогтоомжийн тухай хуульд “дагалдах хууль” гэх ойлголтыг нарийн тодорхойлоогүй, “тухайн хуулийг хэрэгжүүлэхэд шаардлагатай бол” гэснээс өөр ямар нэг шалгуур тавиагүйгээс үүдэлтэй. Өөрөөр хэлбэл, төсвийн тухай хуулийг дагалдуулан анхдагч хууль баталсан

37 МАН-ын бүлгийн дарга Д.Тогтохсүрэн, дэд дарга Х.Булгантуяа, УИХ-ын Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн нарын Монцамэ агентлагт өгсөн мэдээлэл, 2022.10.31 <https://montsame.mn/mn/read/307049>

тухайн цаг үед аль нэг хуулийг дагалдуулан өөр нэг цоо шинэ хууль батлах буюу анхдагч хуулийг дагалдах хууль хэлбэрээр баталж болох эсэх нь тодорхойгүй байсан юм. Гэхдээ Хууль тогтоомжийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-д “Хууль санаачлагч нийгмийн харилцааны төлөв байдал, тулгамдсан асуудлыг судалсны үндсэн дээр шинээр үүссэн харилцааг хуулиар зохицуулах шаардлагатай, эсхүл тухайн нийгмийн харилцааны эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан шинэ хуулиар зохицуулах шаардлагатай гэж үзвэл анхдагч хуулийн төсөл боловсруулна” гэж зааснаас харахад анхдагч хуулийн төсөлд ямар ч тохиолдолд хэрэгцээ шаардлагын тандан судалгаа хийх агуулгыг илэрхийлж байна. Иймд төсвийн тухай хуулийг дагалдуулан анхдагч хууль баталсан нь дээрх шаардлагыг зөрчсөн тохиолдол болжээ. Харин түүний дараа 2023 оны 5 сарын 04-ний өдөр Хууль тогтоомжийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, нэг салбарын харилцааг зохицуулах багц хуулийн төслөөс бусад хуулийн төслийг дагалдуулан анхдагч болон шинэчилсэн найруулгын төслийг өргөн мэдүүлэхийг хориглохоор нарийвчлан зохицуулсан нь дээрх алдааг залруулсан хэрэг болжээ.

Хууль тогтоомжийн төсөл боловсруулахад тавих

ЗӨВЛӨМЖ

Хууль тогтоомжийн тухай хуулийн хэрэгжилт, үр дагаврын үнэлгээг хийж, дагалдах хуулийн төсөл өргөн мэдүүлж буй байдал, холбогдох тооцоо судалгаа, олон нийтийн хэлэлцүүлэг өрнүүлэхтэй холбоотой зөрчил дутагдлыг тодорхойлж, залруулах арга хэмжээ авах;

“Дагалдах хууль” гэсэн ойлголт, түүний агуулга, цар хүрээнд тавигдах шалгуур, процессын шаардлагыг хуулиар нарийвчлан тодорхойлох. Ялангуяа, төсвийн хууль тогтоомж, түүний дагалдах хуульд тавих агуулгын болон процессын тусгайлсан шаардлагыг тодорхой болгох;

Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт заасан тооцоо судалгаа хийх шаардлагагүй асуудлын цар хүрээг улам өргөжүүлж байгааг таслан зогсоох;

Дагалдах хуулийн төсөл боловсруулах шаардлага буюу тухайн хуулийг хэрэгжүүлэхэд “зайлшгүй шаардлагатай” эсэхийг тодорхойлох шалгуур үзүүлэлтийг тогтоож, Хууль зүй, дотоод хэргийн яам, Засгийн газар, Улсын Их Хурал хууль тогтоомжийн төслийн бүрдэлд тавих хяналтаа сайжруулж, хуулийн төслийн бүрдлийг нарийвчлан шалгах үүргээ бүрэн хэрэгжүүлэх;

Анхдагч хуулийн төсөл, эсхүл шинэчилсэн

процессын өөр нэг үндсэн шаардлага нь олон нийт болон холбогдох талуудаас санал шүүмж авах явдал юм. Төсвийн тухай хуулиар улсын төсвийн төслийг олон нийтээр хэлэлцүүлэх тусгай шаардлагыг тогтоосон байдаг. Гэхдээ энэ хэлэлцүүлэг нь төсвийн төсөлд голчлон төвлөрдгөөс түүний дагалдах хуулиудын хувьд хэлэлцүүлэг огт хийгддэггүй гэхэд бараг хилсдэхгүй.

Тэрчлэн Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуульд зааснаар аливаа хуулийн төслийг холбогдох байнгын хороо заавал хэлэлцэж, санал дүгнэлт гаргаж чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулах ёстой. Харин энэ шаардлага нь улсын төсөвт хамаарахгүй бөгөөд тус хуулийн 8 дугаар зүйл төсөв хэлэлцэхтэй холбоотой чуулганы хуралдааны дэгийг ялгаатай байдлаар хуульчилсан байдаг. Өөрөөр хэлбэл, тухайн жилийн төсвийн төслийг аль нэг байнгын хороо тусгайлан хэлэлцэх шаардлагагүй. Дээрхээс үзэхэд төсвийн хууль тогтоомжтой хамт өргөн мэдүүлэгдсэн дагалдах хуулиуд олон нийтийн хэлэлцүүлэггүйгээс гадна бас байнгын хорооны хэлэлцүүлэггүйгээр батлагддаг гэж дүгнэж болохоор байна.

найруулгын төсөл, аливаа хуулийн үзэл баримтлалыг өөрчлөхүйц зарчмын шинжтэй томоохон нэмэлт өөрчлөлтийг заавал холбогдох судалгаа, бие даасан үзэл баримтлалын хамт өргөн барьж байх;

Тухайн жилийн төсвийн тухай хуулийг дагалдуулан ямар хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж болохыг нэрлэн тодорхойлох;

Тухайн жилийн төсвийн тухай хуулийг батлахад Хууль тогтоомжийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.5 дахь хэсгийг чанд баримталж, Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд өөрчлөлт оруулахгүй байх. Эдгээр өөрчлөлтийг хийхэд үзэл баримтлалыг тусад нь боловсруулж, олон нийтээр хэлэлцүүлэх;

Тухайн жилийн улсын төсвийн дагалдах хуулийн төслийг Төсвийн тухай хуулийн 281 дүгээр зүйлийн 281.1.1-ийн дагуу олон нийтээр хэлэлцүүлж хэвшүүлэх зайлшгүй шаардлагатай. Тодруулбал, тухайн жилийн төсвийн төсөлд олон нийтийн хэлэлцүүлэг, байнгын ажиллагаатай цахим хуудас, шуурхай утсаар дамжуулан санал шүүмж авахыг тусгайлан хуульчилсан байдаг. Тус шаардлагад “дагалдах хууль” гэж тусгайлан

заагаагүй ч төсвийн төслийн танилцуулгын бүрэлдэхүүнд багтах тул дагалдаж батлагдах хуулиуд ч мөн адил олон нийтээр хэлэлцэгдэх учиртай. Иймд тухайн жилийн төсвийн төслийг

олон нийтээр хэлэлцүүлэх үед хамт өргөн мэдүүлэгдсэн дагалдах хуулиудын төслийг мөн адил хэлэлцүүлж хэвших шаардлагатай.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

НОМ, ТОВХИМОЛ:

1. Д.Баярсайхан, 2016, “Эрх зүйн онол”, УБ.
2. Ц.Баянмөнх, “Бодлогын шийдвэр, төлөвлөлт, төсөвлөлтийн уялдааг хангах нь: эрх зүйн зохицуулалт, хэрэгжилт” эрдэмшинжилгээний өгүүлэл, УБ.
3. М.Ариунаа, Р.Очирбал нар, 2012, “Төр, эрх

- зүйн онол, үндсэн хууль, захиргааны эрх зүй”, УБ.
4. Монгол улсын Их сургууль, Хууль зүйн сургууль, 2023, “Үндсэн хуулийн болон захиргааны эрх зүйн үндсэн асуудал: хямралын үеийн тулгамдсан асуудал”, УБ

ГАДААД ЭХ СУРВАЛЖ:

1. The Constitution of the Republic of Estonia- Бүгд Найрамдах Эстони улсын Үндсэн Хууль
2. Rules for good legislative practice and legislative drafting. 2012 /<https://www.riigiteataja.ee/en/eli/ee/528122016004/consolide/current/>
3. Referendum Act- Ард нийтийн санал асуулгын тухай хууль /[https://www.riigiteataja.ee/en/eli/](https://www.riigiteataja.ee/en/eli/ee/514112016003/consolide/current)

- ee/514112016003/consolide/current
4. National assembly act. <https://www.law.go.kr/LSW/eng/engLsSc.do?menuId=2§ion=lawNm&query=national+assembly&x=0&y=0#liBgcolor2>
5. National finance act of Korea 2021.
6. State budget act of Estonia 2014

ЭРХ ЗҮЙН ЭХ СУРВАЛЖ:

1. Монгол Улсын Үндсэн хууль Төрийн мэдээлэл эмхэтгэл: 1992 он, №1
2. Төсвийн тухай хууль Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2012 он, №3
3. Монгол улсын 2022 оны төсвийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2021 он, №45
4. Монгол улсын 2023 оны төсвийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2022 он, №47
5. Засгийн газар дахь хяналтын тухай хууль Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2022 он, №47
6. Төрийн хэмнэлтийн тухай хууль Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2022 он, №19
7. Засгийн газрын тусгай сангийн тухай хууль Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2019 он, №48
8. Төсвийн тогтвортой байдлын тухай хууль Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2010 он, №30
9. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль Төрийн мэдээлэл

- эмхэтгэл: 2020 он, №21
10. Хууль тогтоомжийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2015 он, №25
11. “Монгол улсын их хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2020 он, №22
12. Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хууль /Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2001 он, №46
13. Монгол Улсын Их Хурлын тухай хууль / шинэчилсэн найруулга/ Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2020 он, №22
14. Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоол Аргачлал батлах тухай Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2016 он, №9

ЦАХИМ ЭХ СУРВАЛЖ:

1. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, www.legalinfo.mn
2. Legislation | Eesti.ee
3. Legislative work – Riigikogu
4. МОНЦАМЭ агентлагт мэдээ. 2022.10.31-ний дугаар
5. Монгол хэлний их тайлбар толь. Цахим

- хувилбар
6. Legislative process in the Korean Assembly: Drafting and Review Standards of Legislative bill. https://www.ifla.org/wp-content/uploads/2019/05/assets/services-for-parliaments/preconference/2016/cho_presentation.pdf